

Манмин Мэдээ

№ 39 2013 оны 10-р сарын 6

Хүний хүчээр үйлдэх боломжгүй агуу гайхамшигууд

22 орноос ирж оролцсон Манмины Зуны Цуглааныг GCN TV-р шууд дамжуулав



И Жейруг Тэргүүн пастор хамт оролцсон 2013 оны Манмины Зуны цуглаан цаг агаарын хамгийн таатай нөхцөлд бүх үйл ажиллагаа явагдаж байгаа нь (Зураг 1). Сургаалын үеэр (Зураг 4, 6), Уралдаант тэмцээний өдөр (Зураг 5), Галын Наадамын Магтаал Хүндэтгэл (Зураг 2, 3).

2013 оны 8-р сарын 5-8ны хооронд Манмины Зуны Цуглаан Жеонбук аймгийн Мюжу дэх Деогюсан амралтын газарт “Төгс Сүнс” гэсэн сэдэвтэй болж өнгөрлөө (Еврей 10:22). Цуглааны үйл ажиллагааг GCN TV (Жи Си Эн телевиз) (www.gcntv.org)-р шууд дамжуулсан бөгөөд уг цуглаанд Солонгосын Масан, Пусан, Дейжеон, Гвангжу, Чеонан гэх мэт салбар сүмүүдээс ирсэн итгэгчид болон Америк, Израйль, Кени, Эстон, Швед Энэтхэг зэрэг 22 орноос ирсэн олон зочид хамтдаа оролцсон юм.

Эхний өдөр 13:30д Манмин Сүмийн Залбирлын Өргөөний ахлагч хадагтай И Букним Нээлтийн цуглаан дээр итгэгчид зөвхөн Ариун Сүнсний тусламжтайгаар төгс сүнслэг зүрх сэтгэлийг олж авч чадна гэж айлдсан ба мөн тэрээр галын наадмын залбирлаар дамжуулан Ариун Сүнсний дүүрэн байдлыг хүлээн авах ёстой гэж дамжуулсаны дараа оролцогчид залбирал болоод магтан дуугаар өндөрлөсөн юм.

2013 оны Манмины зуны цуглаанд И Жей руг Тэргүүн Пастор нь 2006 оноос хойш 7 жилийн турш оролцохгүй байж байгаад оролцсон зуны цуглаан байсан бөгөөд хүний хүчээр хийж чадахгүй агуу гайхамшигууд бий болсон билээ. Эхний өдрийн оройн 19:30д Тэргүүн Пасторын сургаал эхлэх

үед том том дусал бүхий бороо асгаран орж байсан ч итгэгчид Бурханд итгэж, сургаалыг хөдөлгөөнгүйгээр анхааралтай сонсож байлаа. Яг л энэ үед Тэргүүн Пастор “бороо зогс” хэмээн залбирч, тэдэнд тааламжтай сайхан цаг агаарыг өгөхийг Бурханаас хүсэн гуйхад тэр даруй өтгөн хар үүлнүүд алга болж, шөнийн тэнгэрт одод гялалзан харагдаж эхэлсэн билээ.

И Жей руг пастор “Энэ удаагийн зуны цуглаан нь 2013 оны 7-р сарын эхээр болсон ‘Удирдагч багш нарын сургалт’-н үргэлжлэл болох төгс сүнсний тухай тайлбарлаж, тухайлбал, хир зэрэг Бурханы сэтгэлтэй нэгдмэл болсон, мөн хир их сайныг хураасан, хир зэрэг итгэмжтэйгээр ажилласанаа шалгуулах цаг нь болсон” гэж айлдсан юм. Мөн тэрээр “Бурхан та бүхнийг хоньчноор дамжуулан өгсөн ивээл ерөөлийг санаж, Бурханы авралыг ухаарч ойлгон, хоньчны хүч чадлыг зарлан тунхаглахыг хүсэж байна. Тэр хоньчны үр жимс болсон итгэгчдын үнэрийг хүлээн авахыг хүсэж байна” гэж үргэлжлүүлэн хэлсэн билээ. Тэгээд оролцогчид гэмшлийн залбирал хийсний дараа И Жей руг Тэргүүн Пастор нь өвчин эдгээх залбирал хийлээ.

Үүгээр дамжуулан маш олон хүн өвчнөөсөө эдгэрч, тэднийг эдгээж өгсөн

амьд оршигч Бурханд алдар магтаал талархалыг өргөлөө. Хараа муутай болон сохор хүмүүс хараа орж маш сайн харж чаддаг болж, дүлий хүмүүс сонсож, тахир дутуу хүмүүс тэргэнцэргүй, суга таяггүй явж байлаа. Эдгэрсэн хүмүүсийн гэрчлэл тасралтгүй үргэлжилсээр байсан. Маш олон хүн хорт хавдар, яр шарх, үлд, бамбай булчирхай гэсэн өвчингөөсөө эдгэрсэн тухайгаа гэрчилж байлаа. GCN TV (Жи Си Эн телевиз)-р И Жей руг Тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлыг авч эдгэрсэн нэгэн эмэгтэй зуны цуглаанд оролцож байгаа гэр бүлийнхээ хүмүүст эдгэрсэн тухайгаа ч гэрчилж байлаа.

2 дахь өдрийн өглөөний 9 цаг уралдаан тэмцээний өдөр байсан бөгөөд гадаадын итгэгчид болон салбар сүмийн итгэгчдийн 4 баг байсан. И Жей руг тэргүүн пастор нээлтийн үйл ажиллагаанд “Өтгөн үүлсээр нарыг бүрхэж, салхи илүү хүчтэй салхилах болтугай. Салхи салхил! Гэрэл бий бол” гэж залбирангуут Бурхан хамгийн сайхан тохиромжтой цаг агаараар нөлөөлж өгсөн юм.

Уралдаан тэмцээн орс таталтаар эхэлж, 100 метрийн гүйлт, волейбол, саадтай гүйлт, холын зайн гүйлт, хөл бөмбөг, Солонгос бөхийн барилдаан, гар барилдаан, буухиа

гэсэн төрлүүдээр өрсөлдлөө. Хамгийн сайн хөгжөөн дэмжигч багаар Салбар сүмүүдийн баг шалгарч, харин нэгдүгээр байрын шагналыг гадаадын итгэгчдын баг авлаа. Эрэгтэй шилдэг тамирчнаар Гүми Манмин Сүмийн У Жун ах дүү, эмэгтэй шилдэг тамирчнаар гадаадын итгэгчдийн багийн Ча Сү Хяан туслагч нар тодорсон юм.

3 дах өдөр нь Галын Наадмын Хүндэтгэл Магтаал оройн 8 цагт онцгойлон зассан тайзан дээр Жампин Паркд боллоо. Бүх итгэгчид өөрсдийн баярласан, талархсан сэтгэлийн үнэрийг Бурханд өргөн, яг л тэнгэрийн орны найранд оролцож, Бурхан Аавын агуу их хайранд баярлан цэнгэж байгаа мэтээр аз жаргал баяр баяслаар бялхам дүүрэн байлаа.

Мөн бүх оролцогчид зохиогдож байгаа үйл ажиллагаанд маш сайн хамрагдаж байсан ба гадаадаас ирсэн пасторууд, ажилчид, итгэгчид хадагтай И Букним, И Хи жин, И Хи сон Ким Сү жёон зэрэг пасторуудтай уулзалт тусгай сургалт семинарт оролцов. Угийн дуугаар дамжуулан олон тэмдэгт гайхамшигууд бий болж, агуу эрх мэдэлт хүч чадлын нөлөөгөөр итгэгчдийн итгэл өсч, итгэлийн хадан суурилах, сүнс рүү, төгс сүнс рүү орох бат итгэлийг олж авсан билээ.

Хайр бол уурладаггүй

“[Хайр] зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй.” (1 Коринт 13:5)



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Цаг хугацаа өнгөрөх тусам хайр хЗарим хүмүүс ажил хэрэг нь тэдний хүссэний дагуу болохгүй байхад юм уу, өөрт нь бусдын буруугаас болж ямар нэг хэмжээгээр хохирол учрахад цухалдаж, бухимдах тохиолдол байдаг. Чухамдаа тэдний ийм дүр төрх нь гадагшаа ил гарахыг л уурлах гэдэг.

Хайр хүний зүрх сэтгэлийг өөдрөг, уян зөөлөн, эерэг хандлагатай болгож байдаг ч уурлаж, уцаарлах нь хүний сэтгэлийг шархлуулж, уруу дорой, гутранги, болгож, харанхуйгаар дүүргэдэг байна. Ингэж сэтгэлийг харанхуйлдаг учир Бурханы хайран дотор байж чадахгүй, сүнсний өсөлт ч маш удаан байхаас аргагүй юм.

Бидний дайсан сатан, чөтгөрүүд нь Бурханы хүүхдүүдийг уураар дамжуулан бүдрүүлж, унагааж байдаг. Тэдний гол урхи, мэх бол үзэн ядалт, болон уур юм.

Тэгвэл бид уурлахгүй, байж сүнслэг хайрыг эзэмшин, Бурхандаа алдрыг өргөсөн хүүхдүүд болохын тулд яах хэрэгтэй вэ?

1. Зөвт байдлын төлөө эсэргүүцэх болон уурлах, уцаарлахын ялгаа

Уцаарлах, уурлах гэдэг нь заавал харааж зүхэж, хашгирч, уурлаж, хүч хэрэглэхийг хэлдэггүй. Хэрэв таны нүүр царай хувьсхийн өөрчлөгдөж, ярианы өнгө тань гэнэт огцом өөрчлөгдөж байвал энэ бүгд таныг ууртай байна гэдгийг илэрхийлж байдаг. Хир зэрэг уурлаж байгаа нь нөхцөл байдлаас шалтгаалан уураа гадагшаа гарах, дотроо уурлах гээд өөр өөр байдаг. Гэвч энэ нь хэн нэгнийг хараад түүнийг уурлаж байна гэж бодох, шүүн дүгнэж, буруутгаж болно гэсэн үг биш. Хэн ч хэн нэгний сэтгэлийг зөв тодорхойлоход хэцүү байдаг. Зөвхөн Бурханаас өөр хэн ч хүний зүрх сэтгэлийг яг үнэн зөвөөр харж, уншиж чаддаггүй юм.

Матай 21-р бүлэгт Есүс сүмд худалдаа хийж байсан хүмүүсийг хөөсөн тухай гардаг. Дээгүүр Өнгөрөх баяраар Иерусалимын сүмд ирсэн хүмүүс ширээн

дээр мөнгө сольж, мал амьтадыг худалдан авч, бас зарж байлаа.

Ердийн үед Есүс нь маш даруу төлөв, хүнтэй хэрэлдэж муудалцдаггүй, ямар ч хүн Түүнийг гудамжинд хашхирч байхыг хараагүй юм. Гэвч сүмд болсон нөхцөл байдлыг харвал Тэр бүр шал өөр байдалтай болсоныг харж болно. Тэр мал амьтадыг ташуураар ташуурдан хөөж, мөнгө солигчдын ширээг болон тагтаа худалдаж байсан хүмүүсийн ширээг хөмөрч хаядаг.

Хүмүүс Есүсийг хараад уурлаж байна гэж бодсон байж магадгүй. Гэвч яг энэ үед Тэр уурлаагүй харин үнэн, зөвт, шударга байдлын төлөө эгдүүцэн зэвүүцэж байсан юм. Хэдий их үр ашигтай зүйл байсан ч Бурханы сүмийг худал хуурмаг, шударга бус зүйлээр бузарлахыг зөвшөөрөхгүй гэдгийг Тэр ойлгуулж, ухааруулсан юм. Энэ мэт үнэн зөв, шударга байдлын төлөө эгдүүцэн зэвүүцэж, жигших нь үнэнч шударга, төгс хайрын Бурханыг хайрлаж байгаа хэрэг юм.

Марк 3-р бүлэгт Амралтын өдөр Есүс синагог дотор нэгэн хагингар гартай хүнтэй уулздаг. Хүмүүс Түүнийг буруутгахын тулд Амралтын өдөр тэр хүнийг эдгээх нь үү, үгүй юу гэж харж байлаа. Яг энэ үед Есүс хүмүүсийн бодлыг мэдээд “Амралтын өдөр сайныг үйлдэх эсвэл мууг үйлдэх, амь аврах эсвэл амь хөнөөхийн аль нь хуульд нийцэх вэ?” (Марк 3:4) гэж асуухад тэд юу ч ярьж чадаагүй.

Тэр үед хорон муу хүмүүс Есүсийг сайн үйлс хийж байхыг нь хараад ямар нэг зүйлээр буруутгаж алахыг л хичээж байлаа. Есүс зөвхөн үнэнийг ойлгож ухаараасай, гэм нүгэл хорон муугаасаа эргээсэй гэсэндээ заримдаа тэдний үнэн дүр төрхийг хатуу зэмлэдэг байв. Ингэж Тэр зөвт байдлын төлөө худал хуурмаг, бузар булайг жигшин зэвүүцэж эсэргүүцсэнээр Фарисайчууд болон Хуулийн багш нарыг жинхэнэ үнэн амь руу замчилж, ухааруулахыг хүссэн Түүний агуу хайр байсан юм. Үүнээс харахад уурлах болон зөвт байдлын төлөө эсэргүүцэх нь хоорондоо их ялгаатай юм. Гэм нүгэл хорон муугийн ямар ч хэлбэргүй болсон хүн сүнснүүдийг аврахын тулд хорон мууг буруутган зэмлэж чаддаг.

2. Хүмүүс яагаад уурладаг вэ?

Хүмүүсийн уурладаг хамгийн гол шалтгаан бол бусад хүмүүс өөртэй нь үзэл бодол, санаа сэтгэлээрээ нийлэхгүй байх үед их уурладаг. Өөр өөр орчин нөхцөлд өсөж, сурч боловсорсон учраас хүн бүрийн санаа сэтгэл, үзэл бодол нь өөр хоорондоо ялгаатай байдаг. Таны баримталдаг үзэл бодол, дэг журам, ааш араншин бусад хүмүүсээс өөр байдаг учраас та бусдыг өөрийнхөөрөө байлгах гэвэл нөхцөл байдлыг улам хэцүү болгохоос өөр ямар ч

тус нэмэргүй байх болно.

Хүмүүсийн уурлаж бухимддаг бас нэг өөр шалтгаан бол бусад хүмүүс танд дуулгаваргүй, таны үгийг дагахгүй бол уурладаг. Хэрэв та дээгүүр албан тушаал хашдаг, эсвэл бусдаас аль нэг талаараа өөрийгөө илүү гэж бодвол хэн нэгэн хүнийг өөрийнхөө үгэнд дуулгавартай байгаасай гэж хүсдэг байж болох юм. Мэдээж хэрэг доод тушаалын хүн өөрөөсөө албан тушаал дээгүүр хүнийг хүндэтгэх, тэдний өгсөн үүрэг даалгаварыг нь биелүүлж захирагдах ёстой ч хүмүүсийг хүч хэрэглэн дарамтлах эрх байхгүй. Хэрэв дарга, удирдагч хүн доод албан тушаалын хүнийгээ санал бодлыг харгалзахгүй хавчлага дарамт үзүүлэн албан хүчээр захирч удирдвал хамгийн буруу юм.

Үүнээс гадна хор хохирол учруулах үед, шударга бус хандсан тохиолдолд, хэн нэгэн ямар ч учир шалтгаангүйгээр атаа жөтөө, өс хонзон санах үед, ажилчид нь өөрийнх нь хүссэн хэмжээнд хүртэл ажиллаж чадахгүй бол, эсвэл юу хийхийг нь заагаад байвал, хүмүүс таны тухай муугаар яриад, доромжлох гэх мэт тохиолдлуудад маш амархан уурладаг байна.

Уурлах үед хүний сэтгэлд хамгийн түрүүнд муухай мэдрэмж, эвгүйцэл, дургүйцэл төрж дараа нь уур нь үйлдлээр ил гардаг. Танд ингэж муухай мэдрэмж, эвгүйцэл, дургүйцэл төрж байвал яг уурлахын өмнөх шатан дээрээ яваад байна гэсэн үг юм. Бид ингэж уурлаад байвал Бурханы хайран дотор байж чадахгүй харин ч бидний сүнсний өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлж, хорон муу, атгаг сэтгэлдээ баригдаж, үнэн дотор өөрчлөгдөн шинэчлэгдэж чадахгүй юм.

3. Уурлаж, уцаарласаны үр дагавар

Елиша өөрийн багш Елиагаас хоёр дахин их хүчийг авч Бурханы агуу их эрх мэдэлт хүчийг гаргадаг байв. Тэр үр хүүхэдгүй эмэгтэйг хүүхэдтэй болгож, үхсэнийг амилуулж, уяман өвчнийг эдгээж, залбирлаар дайсануудаа ялж байсан. Тэр амьдралынхаа туршид Бурханы агуу их эрх мэдэлт хүчийг гаргаж, бусдад харуулж чадсан боловч өвчнөөр нас барсан билээ. Яагаад тэр өвчин тусаж нас барсан бэ?

Хаадын дэд 2:23-г уншвал Елиша бараг үсгүй учраас тийм ч сайхан харагддаггүй байсан тул түүнийг Бетел руу явж байхад хотоос хэдэн хүүхэд гарч ирээд элэглэн шоолж, “Халзан толгойтоо, чи дээшээ яв. Халзан толгойтоо, чи дээшээ яв!” гэж доромжилдог. Елиша тэдэнд дахин шоолохгүй байхыг сануулж хэлсэнч хүүхдүүд бүр их шоолж доромжилсонд тэвчээр нь барагдаж тэднийг харахад модон дотроос хоёр эм баавгай гарч ирээд

42 хүүхдийг хүү татаж тасдаж хаясан.

Энэ үйл явдал нь хэдийгээр хүүхдүүд түүнийг маш бүдүүлэгээр шоолж доромжилсон нь тэдний буруу байсан ч Елишагийн дотор хорон муу, атгаг, уур хилэн байсан учраас өвчнөөр үхэх шалтгаан болсон юм. Энэ явдал нь бид бүхэн Бурханы хүүхдүүдийн хувьд ууртай байж болохгүй гэдгийг харуулж байна. Иаков 1:20-г уншвал “Учир нь уур хилэн Бурханы зөвт байдлыг биелүүлдэггүй юм” гэж мөн л бидэнд илүү тодорхой батлан хэлж байна.

4. Уурлахгүй байхын тулд

Доош нь тултал нь шахсан пүршны даралтыг авахад пүрш гэнэт дээшээ зад тавин тэлдэгтэй адил та уураа дотогшоо бариад хичнээн их цаг хугацаа өнгөрсөн ч нэг л өдөр таны дотор хуримтлагдсан уур хилэн тэсэрч дэлбэрэх болно. Уурлахгүй байхын тулд бидний дотор байгаа муу муухай мэдрэмж, уураа нууж дарах, тэсэж тэвчих ёсгүй харин бүгдийг нь хаях хэрэгтэй. Тэгээд оронд сайхан мэдрэмж, сайхан сэтгэл, хайрыг зүрх сэтгэлдээ бий болгох хэрэгтэй юм.

Мэдээж бид ганц өдрийн дотор бүх уур хилэнгээ хаяж, хайр сайхан сэтгэлээр зүрх сэтгэлээ дүүргэж чадахгүй боловч бид өдөр бүр үргэлжлүүлэн хичээн зүтгэх шаардлагатай. Эхлээд уур хүргэсэн нөхцөл байдалтай нүүр тулах үед уурлахгүй байхын тулд өөрийгөө сайн хянаж, уурлахгүй байх дасгал суургууль хийх хэрэгтэй. Яг уур хүрэх үед одоо би уурлавал надад ямар ашиг тустай зүйл болох вэ гэдгийг сайн бодож үзэх цаг гаргаасай гэж би та бүхнээс хүсэж байна. Тэгвэл та дараа нь ичиж бас харамсахгүй байх болно.


Үүнчлэн бид сүнслэг хайрыг авахын тулд залбирч, хүлээцтэй тэвчээртэй байвал Ариун Сүнсний тусламжтайгаар уурлахад бэлэн байдаг муу муухай мэдрэмжийг хаяж чадах болно. Өмнө нь арван удаа уурладаг байсан бол ес, найм, долоо гэх мэтчилэн баг багаар багасан хаягдсаар эцэст нь ямар ч хүн таны дургүйг яаж ч хүргэж байсан та амар тайван байж чаддаг болно.

Хайрт итгэгч ахан дүүс минь, сүм дотор уурыг тань үнэхээр их хүргэх нөхцөл байдалд итгэлийн ахан дүүсийнхээ өмнө хүлээцтэй байж, тэвчсэн ч ажил дээрээ эсвэл гэртээ амархан уурлаж байна уу? Бурхан зөвхөн сүм доторбайдаггүй юм шүү! Бурхан бидэнтэй үргэлж хамт, бүр бидний дотор байдаг. Тэр хэзээ ч хаана ч хүн бүрийн зүрх сэтгэлийг харж, бодлыг уншиж чаддаг. Таны хэлж ярьж байгаа бүхий л үг, хийж байгаа үйлдэл тань Бурханыг алдаршуулахын төлөө байгаасай хэмээн Их Эзэнийхээ нэрээр хүсэн ерөөе!

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг	
Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг		
Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773
www.manmin.org
www.manmintv.org

Өөрийгөө таньж мэдэхийн төлөөх амьдралын мэргэн ухаан

“Тиймээс Тэнгэрлэг Эцэг тань төгс байдаг шиг та нар төгс бай.” (Матай 5:48)

“Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл ‘Би ариун учраас та нар ариун байгтун’ бичигдсэн юм.” (1 Петр 1:15-16)

Бидний Тэнгэрлэг Бурхан Аав маань хайртай хүүхдүүд нь төгс, ариун байгаасай хэмээн хүсдэг. Тэгвэл ухаалаг итгэгчид яах ёстой вэ? Бид Бурханы үгэн дээр суурилан өөрсдийгөө таньж мэдэн, гэм нүглийг цус урсгах мэт тэмцэж, хорон муугийн бүхий л хэлбэрийг хаях ёстой юм. Доор дурьдсан зүйлсээр өөрийгөө хэрхэн таньж мэдэн, хаясан болохыг шалгацгаая.



А, Б хоёр шилэн аяганд байгаа усыг хальт харахад хоёулаа цэвэрхэн харагдаж байгаа боловч А шилэн аяганы ёроолд нь элс, шороо байгаа ба Б шилэн аяган дахь нь цэвэр ус юм (Зүүн талын зургийг харна уу). Халбагаар хоёр шилэн аягатай усыг хутгахад А шилэн аягатай усыг ёроолд нь байгаа зүйл нь дээш хөөрөн бохирдуулахад, харин Б шилэн аягатай ус цэвэрхэн хэвээрээ байна. (Баруун талын зургийг харна уу). Үүн шиг бид зүрх сэтгэлдээ байгаа бүх хорон муугийн хэлбэрээ хаясны дараа л ямар ч нөхцөл байдалд цэвэрхэн, тунгалаг, сайхан байж чадна гэдгийг харуулж байна.

1 Та бусдын хүслийг эв нэгдэлтэй дагадаг уу?
Зарим үед уурлаж, яаж ийгээд өөрийгөө зөвтгөх шалтаг тайлбар тавьдаг хүмүүс их тохиолддог. Бухимдал тавгуйтлээ илэрхийлсэн, цухалдсан үг шидэж байдаг ч үнэхээр уур хилэнгүй бол ямар үйлдэл, хэл яриагаар бусадтай харьцах бол? Бурханд таалагдахгүй хэл яриа, үйлдлийг бид хийхгүй байх нь мэдээж бөгөөд бусдыг ойлгож, тэдний хүслийг дагах, нийцүүлэхийг хичээх хэрэгтэй. Тэдний бодож байгаа бодол санаа, үйлдэж байгаа үйлдэл нь биднийхээс өөр байсан ч бидэнд ашиггүй, хохиролтой байсан ч худал хуурмагтай хамааралгүй бол эв нэгдэл дотор амар тайвнаар өөрсдийгөө бусадтай нийцүүлдэг.

2 Та бүх хүнтэй эв нэгдэлтэй байж, хувирашгүй үнэнчээр ажилдаг уу?
Хэрэв танд тавгүй сэтгэл хаягдаагүй үлдсэн бол гадна талаараа хамт ажилдаг хүнтэйгээ сөргөлдөхгүй ч гэсэн та түүнтэй таарч тохирохгүй байвал энэ таны дотор уур хилэн байсаар л байх бөгөөд түүний сул тал л нүдэнд харагддаг. Уурлах, бухимдах байдлыг хаяж, цэвэрхэн болвол та бүх хүнтэй эв нэгдэлтэй байж чаддаг ба бусдыг давуу талыг л олж харах болдог. Мөн сэтгэлд тань гомдоллох шинж чанар байхгүй бол хичнээн их зүтгэж ажилласан ч гэсэн хүлээн зөвшөөрөгдөхгүй байлаа ч та баяртайгаар, хувирашгүй үнэнчээр ажиллаж чаддаг байна.

3 Бусдыг магтаж байхад та бас адилхан магтаж, баяртай байж чаддаг уу?
Та бусдыг хайрлаж чадахгүй л байвал таны дотор үзэн ядалт байна гэдгийг мэдэх хэрэгтэй. Хайр бол үзэн ядалтаа хаясаныг батлан харуулдаг. Тиймээс хайртай хүмүүстээ магтаж, урамшуулахад ямар ч хардах, атаархах зүйлгүй харин ч хамтдаа баяр жаргалыг мэдэрдэг. Үзэн ядалтаас хардах, атаархах сэтгэл төрдөг учир бусад хүмүүс магтуулж байхад хамтдаа чин сэтгэлээсээ баярлаж, мөн түүнийг хүлээн зөвшөөрөн сайшааж байна уу гэдгээ эргэн харж, үзэн ядалт байна уу, үгүй юу гэдгээ шалгаж нэг үзээрэй.

4 Та үргэлж үнэн, шударга ярьдаг уу?
Хэдийгээр та хууран мэхлэх санаа байгаагүй боловч таны үг үнэн биш бол таны сэтгэлд худал хуурмаг байсаар байна гэсэн үг. Та хэн нэгэнд долоо хоногын өмнө “Бурханы үгийг судлах тусам илүү их аз жаргал баяр хөөртэй байгаа болохоор цаашдаа үг сургаалаар хичээнгүйлэн зэвсэглэх болно” гэж хэлсэн боловч яг үнэндээ хийгээгүй бол түүнд үнэнийг л хэлэх хэрэгтэй. Ингэж бид өөрсдийн дүр төрхөө сайтар ажиглан, энэ мэт үг яриандаа анхаарал хэрэгтэй.

5 Та бусад хүний сайн талыг, давуу талыг нь хардаг уу?
Буруутгал, шүүмжлэл гэдэг нь муулах, гүтгэх, шалтаглах, харьцуулах, буруутгахтай хамт дагалдаж байдаг. Ерөнхийдөө би хир зэрэг бусдыг дүгнэдэг вэ? мэдэхийн тулд “Би хэр зэрэг бусдын сайн талыг харж бас магтан урамшуулдаг вэ?” гэдгээ бодох хэрэгтэй юм. Мэдээж бусдын алдаа дутагдалын талаар гүнзгий бодож, шивэр авир хийдэггүй ч урьдын л адил бусдын сул тал сайн харагдаад байвал таны дотор бусдыг дүгнэх шүүх шинж чанар одоог хүртэл байна гэсэн үг! Хүмүүсийн сайн талыг харж чин сэтгэлээсээ магтдаг хүн тэднийг дүгнэж шүүн, буруутгадаггүй байна.

6 Танд ашиггүй байсан ч амласан амлалтандаа хүрч чаддаг уу?
Хувирамтгай хүн нь мэдээж өөртөө болоод бусдад амласан амлалтандаа хүрдэггүй, түүнчлэн Бурханы өмнө амласан амлалтаа хүртэл байн байн өөрчилж хувирч байдаг. Бид өчүүхэн жаахан зүйлээс эхлээд амлалтаа биелүүлэхийг хичээх үед л хувирамтгай зангаасаа салж чадна. Бид бодлогогүй, түргэн хөнгөн хуумгай шийдвэр гарган амлах ёсгүй бөгөөд зөвхөн Бурханы өмнө ч бус хүмүүсд амлахаасаа өмнө маш болгоомжтой ухаалаг шийдвэр гаргаж, нэгэнт амласан л бол бидэнд ашиггүй хор хохиролтой байсан ч биелүүлж чадвал бид бүхэн хувирамтгай зан чанарыг хаяж чадна.

7 Та зүрх сэтгэл, оюун бодлоо Эзэний хайраар хир их дүргэдэг вэ?
Матай 5:27-28д эмэгтэй хүнийг тачаадан харсан хүн зүрхэндээ аль хэдийн түүнтэй завхайрсан гэж Эзэн хэлсэн билээ. Бид завхай байдлыг үйлдлээр төдийгүй зүрх сэтгэл, оюун бодлоосоо уг үндсээр нь хүртэл авч хаях хэрэгтэй. Хэрэв та одоог хүртэл эсрэг хүйсийнхээ хүнийг хараад “Ямар хөөрхөн хүүхэн вэ, ямар сайхан залуу вэ” гэж бодож байгаа эсэх, мөн сайхан хосуудыг хараад атаархалын нүдээр харж байна уу, эсвэл ганцаардаж байна уу гэдгээ шалгаж үзэнгээ та зүрх сэтгэлээ Эзэнийг хайрлах хайраар дүүргэх хэрэгтэй.

8 Та бусдад өгөхдөө хир зэрэг сэтгэл хангалуун баяр хөөртэй байдаг вэ?
Хүсэл тачаал нь гэм нүгэлийг төрүүлдэг. Хүсэл тачаал, шуналгүй бол бусдад атаархах сэтгэл ч төрөхгүй, бөгөөд илүү авъя, эзэмшье, гэсэн хүсэлгүй учир гэм нүгэл үйлдэх боломжгүй юм. Хэрэв танд шуналын сэтгэл байхгүй бол ямар ч нөхцөлд сэтгэл хангалуун, амьдардаг ба харин ч бусдад өгөхдөө баяр хөөртэй байх болно. Та Бурханаас гуйсан зүйлээ харахан аваагүй байсан ч талархаж, аз жаргалтай байж чаддаг.

9 Та авсан ивээл, ач тусыг маргалгүйгээр талархан ачийг хариулдаг уу?
Өөрийн эрх ашгийг түрүүнд тавьж ийш тийш хөдөлдөг, зальт сэтгэлд урвах, золиослох зан чанар байна гэсэн үг. Бурханаас авсан ивээлээ маргалгүй ачийг хариулдаг хүн болохын тулд яах хэрэгтэй вэ? Надад өөрийн эрх ашгийг эрж хайх сэтгэл юм уу, бардамнах сэтгэл байна уу гэдгээ шалгаж үзэнгээ мөн надад туслаж тэмжрэн хүмүүсийг цаг үргэлж санаж дэлархдаг уу гэдгээ эргэн харах хэрэгтэй юм.

“Бүтээгч Бурханы Эрх мэдэлт хүч ба хайраар Аз жаргалд умбасан Пакистан”

Египетээс гарсан нь 15:25д Марагийн гашуун ус Мосегийн залбирлаар амтлаг уух ус болон өөрчлөгддөг тухай байдаг. 2000 оны 3-р сард Доктор И Жей руг Тэргүүн пасторын чин сэтгэлийн залбирлаар Жеоннам Аймгийн Муан Гүн дэх Муан Манмин Сүмийн өмнөх далайн шорвог ус сайн чанарын уухад тохиромжтой амтат ус болж өөрчлөгдсөн билээ. Энэ Муан амтат усанд Бүхнийг Бүтээгч Бурханы агуу их хүч агуулагддаг бөгөөд хэн ч итгэлээрээ ууж, хэрэглэх юм уу түрхэж, цацахад гайхамшигтай эдгэрлийн болоод залбирлынхаа хариултыг авах хүч чадлыг харах болно. Есүс Христийг хүлээн авч Бурхантай уулзсан маш олон итгэгчдийн зүрхний хүсэл энэ Муан амтат усаар дамжуулан биелсэн билээ. Ялангуяа лалын шашинтай Пакистаны Бүгд Найрамдах Улсад ч болсон гайхалтай үйл явдлыг та бүхэн танилцуулан Бурханыг алдаршуулж байна.



“Би хүүхэдтэй болох ерөөлийг авсан”

Мускрат Асиф эгч дүүс (Шинэ Апостолик Сүм)

Би 10 жилийн турш хүүхэдтэй болж чадахгүй байлаа. Нөхөр бид хоёр хүүхэдтэй болохын тулд бүх арга хэмжээг авсан боловч хүүхэдтэй болж чадаагүй. 2012 оны 3-р сарын 14 нд хөрш Естер Ноужен эгч дүүсийнд зочлон очиход тэрээр надад Муан амтат усны тухай тайлбарлаж өгөхөд би энэ талаар сонсмогцоо Муан амтат уснаас итгэлээрээ уувал Бурханы хүчээр хүүхэдтэй болж чадах юм шиг итгэл төрсөн юм. Тэгээд чин сэтгэлээсээ залбирч Муан амтат уснаас уусан.



Нэг өдөр миний толгой маш их хүчтэй өвдөж ээжтэйгээ хамт эмнэлэг руу явсан. Эмнэлгийн үзлэгээр би жирэмсэн болсон байсан юм. Халеллүяа! Бид үнэхээр их баярлаж сэтгэл хөдлөм үйл явдал болсон юм. 2013 оны 2-р сарын 14нд эрүүл саруул хүү төрүүлсэн. Муан Амтат усанд шингэсэн Бурханы эрх мэдэлт хүч үнэхээр гайхамшигтай. Залбирал гуйлтанд минь хариулж ивээл ерөөлийг дүүрэн өгсөн хайртай Эзэндээ бүхий л алдар магтаал талархалыг өргөж байна!

“Амьгүй хүүхэд гарах байсан ч эрүүл саруул хэвийн хүүхэдтэй болсон”

Лапия Лиакет итгэгч (СССИ Сүм)

2012 оны 4-р сард би 4 сартай жирэмсэн байсан. Ураг орчмын шингэн түрүүлж гарч, усгүй болсон учраас аборт хийлгэх хэрэгтэй гэж эмч хэлсэн ч Бурхан намайг хамгаална гэдэгт би итгэлтэй байлаа. Пастор Сайкуа Ашрафаас миний төлөө залбирч өгөхийг гуйсан. Тэр Муан амтат усанд Бурханы хүч шингэсэн байдаг учраас итгэлээрээ уугаарай гэж надад хэлээд залбирч өгсөн юм. Би Амтат усыг хэрэглээд олон хүн маш олон төрлийн өвчнөөс эдгэрсэн гэж сонсож байсан учраас итгэлээрээ уусан.



Түүний дараа надад ямар ч өвчний шинж тэмдэг байхгүй, зовиургүй байсаар гэнэт 7 дахь сардаа маш их хүчтэй өвдсөн. Ямар ч усгүй болсон учраас 2 цагийн дотор хүүхдийг гаргаж авахгүй бол үхнэ гэж эмч дахин хэллээ. Гэсэн ч би амтат усаа хэрэглэсээр эрүүл саруул хөөрхөн охинтой болсон. Миний охин 7 сартай төрсөн одоо эрүүл саруул сайхан өсөж байгаа. Би охиндоо хэдэн дусал амтат ус өгч өдөр бүр биенд нь түрхдэг. 2013 оны 7-р сард охин маань 1 ой хүрч төрсөн өдрийг нь тэмдэглэсэн. Би Бурхандаа бүх алдар магтаал, талархалыг өргөж байна.

“Хумхаа өвчин эдгэрсэн”

Пастор Жон Матто (Жон Веслей Баптист Сүм)

Нэгэн өдөр Карачи хотоос Саба гэдэг эмэгтэй Татад амьдардаг надтай уулзахаар ирээд залбирч өгөхийг чин сэтгэлээсээ дахин дахин гуйв. Түүний нэг настай хүү нь долоон сарын турш хумхаа өвчнөөр өвчилж өдөр бүр их өндөр халуурч амь нас нь аюултай байдалд байна гэв.



Тэгээд 2013 оны 2-р сарын 15 Карачи руу түүний хүүгийн төлөө залбирч өгөхөөр явлаа. Би түүнд амтат ус уулгаж, залбирч өгөөд гэртээ буцаж ирээд удаагүй байтал Саба хүүгийнх нь халуун буурч, маш сайн унтаж байна гэж утсаар ярьсан. Одоо түүний хүү эрүүл саруул сайн өсөж байгаа. Энэ бүх ивээл зөвхөн Бүхнийг Бүтээгч Бурханых юм. Халеллүяа!

“Би аюулгүй төрсөн”

Шахзиа Тариг эгч дүүс (СССИ Сүм)

2009 оны 5 сарын 23нд би гэртээ төрсөн. Маш хүнд төрөлт байсан. Би яг төрөх үед ухаан алдаад маш хүнд байхад Ариун Сүнс надад амтат усыг сануулсан.



Тэгээд гэр бүлийнхэнээсээ Муан амтат усыг авчирч өгөхийг гуйхад манай бэр эгчид жаахан байсаныгаа надад өгсөн. Би амтат усыг уугаад хүүхдээ хэвийн төрүүлсэн. Хүү бид хоёрыг аюулаас хамгаалж өгсөн Бурхандаа үнэхээр их талархаж байна. Бас яг эгзэгтэй хүнд үед амтат усыг надад сануулж өгсөн Ариун Сүнсэнд маш их, чин сэтгэлийнхээ угаас талархаж байна.

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул, 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин